



## ЗАРЛАГЫН ӨӨРЧЛӨЛТ: ӨМНӨХ ОНООС 68.3 ТЭРБУМ ₮↑

Үүнд хамгийн ихээр нөлөөлж буй зарлагын өсөлтүүд нь:

- Хүүхдийн мөнгөн тэтгэмж: 21.1 тэрбум ₮↑
- Халамжийн тэтгэвэр (тэтгэвэр авагчдын тооны өсөлтөөс шалтгаалсан): 18.1 тэрбум ₮↑
- Цалинтай ээж: 13.9 тэрбум ₮↑
- Асаргааны тэтгэмж: 12.7 тэрбум ₮↑



2020 ОНЫ  
НИЙТ  
ЗАРЛАГА

**756.5**  
тэрбум төгрөг

## ЗАРЛАГЫН 2019 БА 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (ЗАРЛАГЫН АНГИЛЛААР)

	2019 он	2020 он	Зөрүү
НИЙТ	688.2	756.5	68.3
Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	218.9	240	21.1
Халамжийн тэтгэвэр	99.5	117.6	18.1
Цалинтай ээж	96.8	110.7	13.9
Асаргааны тэтгэмж	37.5	50.2	12.7
Хоол тэжээлийн тусламж дэмжлэг	42.2	42.2	
Халамжийн бусад хөнгөлөлт	31.1	31.1	
Алдарт эхийн тэтгэмж	29.4	29.4	
Амьжиргааг дэмжих тусламж	24	27.8	3.8
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	26.1	26.1	
Насны хишиг	22.3	22.3	
Жирэмсэн эхийн тэтгэмж	18.1	18.1	
Халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх (инфляцитай уялдуулан нэмэгдүүлэх)	-3.7	21.2	17.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж	12.3	12.3	
Ахмад дайчин, алдар цолтон	6.4	6.4	
Үйл ажиллагааны зардал	2	2.7	0.7
Олон нийтийн оролцоо		1.8	1.8
Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	0.18	0.3	0.12

Асаргааны тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих тусламж, цалинтай ээж, хүүхдийн мөнгө хөтөлбөрүүдийн зарлага өмнөх оноос 10-33 орчим хувиар өснө.





## МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТӨД ТӨР, ЗАСГИЙН ЗҮГЭЭС АНХААРАХ АСУУДЛУУД

- ☑ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн өнөөгийн төрлүүдийг дахин авч үзэн, салангид жижиг хөтөлбөрүүдийг нэгтгэн мөнгөн хэмжээг нэмэгдүүлэх замаар иргэнд очиж буй тусламж, дэмжлэгийг бодитой болгох. Жишээлбэл, насны хишиг, ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт зэргийг нэгтгэн ахмад настны нэгдсэн хөтөлбөр боловсруулж шаардлагатай ахмад настнуудад бодитой дэмжлэг болохуйц тусламж, үйлчилгээг үзүүлдэг болох;
- ☑ Протез, ортопедийн хэрэгсэл, амралт сувилалд амрах зардлаас хөнгөлөх зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг болох;
- ☑ Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийг нөхцөлт болгож нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай болон олон хүүхэдтэй өрхийн хүүхдэд олгох хэмжээг нэмэгдүүлж бусад хүүхдүүдэд олгох мөнгөн тэтгэмжийн хэмжээг бууруулж аажимдаа зогсоох;
- ☑ Халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээнд зарцуулж байгаа хөрөнгийн хяналт, зарцуулалтын үр ашгийг сайжруулах зорилгоор сангийн төлөвлөлт, зарцуулалтын удирдлагыг цахим систем ашиглан хэрэгжүүлэх, хөтөлбөрүүдийн үр дүнд тогтмол хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай төсвийг төлөвлөх.

### 2020 ОНЫ ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТӨД АНХААРАХ АСУУДЛУУД

- ☑ 2020 оны төсвийн төсөлд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмжид 31.12 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөсөн. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу уг тэтгэмж олгох нөхцөл, болзлыг Засгийн газраас баталсан журмаар зохицуулах ёстой бөгөөд журам боловсруулагдсан эсэх нь одоогоор тодорхойгүй байгааг анхаарах.

